



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 03 сарын 30 өдөр

Дугаар А/130

Арвайхээр

Зардал хуваарилах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.“а”, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3. дахь заалт, Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2020 оны “Арга хэмжээний эрх шилжүүлэх тухай” А-65 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумдад өвс тэжээлийн агуулах, саравч засварлах, инженерийн хийцтэй худаг, бог мал угаах банн шинээр барих төсөл, арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2. Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-д даалгасугай.


ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100283

Аймгийн Засаг даргын 2020 оны 03
 дугаар сарын 30-ны өдрийн 4130 дугаар
 захирамжийн хавсралт



Сумдад өвс тэжээлийн агуулах, саравч засварлах, инженерийн хийцтэй худаг, бог мал угаах банн шинээр барих төсөл, арга хэмжээний зардлын хуваарилалт

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /мян төг/
1.	Сумдад өвс тэжээлийн агуулах, саравч засварлах /Бат-Өлзий, Хужирт сум/	82 228.5
2.	Сумдад өвс тэжээлийн агуулах, саравч засварлах /Есөнзүйл, Бүрд сум/	82 228.5
3.	Сумдад өвс тэжээлийн агуулах, саравч засварлах /Тарагт, Төгрөг, Хайрхандулаан сум/	123 343.0
4.	Инженерийн хийцтэй худаг шинээр гаргах /Хархорин, Бүрд, Баян-Өндөр, Сант, Өлзийт, Хужирт, Зүүнбаян-Улаан, Арвайхээр, Баянгол, Есөнзүйл сум/	253 000.0
5.	Инженерийн хийцтэй худаг шинээр гаргах /Богд, Баруунбаян-Улаан, Гучин-Ус, Тарагт, Уянга, Нарийнтээл, Хайрхандулаан, Бат-Өлзий, Төгрөг сум/	253 000.0
6.	Бог мал угаах банн шинээр барих /Тарагт, Төгрөг, Богд, Нарийнтээл, Арвайхээр, Гучин-Ус сум/	120 000.0
7.	Бог мал угаах банн шинээр барих /Баян-Өндөр, Баянгол, Бүрд, Есөнзүйл, Өлзийт, Сант сум/	120 000.0
	НИЙТ ДҮН	1 033 800.0